

Ноолуурын тогтвортой төсөл Мэтгэлцээн

2-р хэсэг: Мэтгэлцээн

Энэ дасгал нь сурагчдад экологийн иймэрхүү асуудал ямар нарийн төвөгтэй байж болохыг ойлгоход тусална. Ноолуурын тогтвортой төсөлд оролцож буй сонирхогч талын байр суурийг баримтлан, тэдний үзэл бодлыг хамгаалан мэтгэлцсэнээр суралцагчид хэлэлцүүлгийг өөриймсүүлж эзэмших болно. Түүнчлэн янз бүрийн үзэл бодлыг харьцуулснаар суралцагчид эрдэм шинжилгээний ажлын салбар хоорондын талыг нь харах болно.

Зорилт:

- Ноолуурын тогтвортой төсөлд оролцож буй өөр өөр сонирхогч талын санаа бодлыг ойлгох
- Томоохон хэмжээний экологийн санаачилгыг төлөвлөж, гүйцэтгэхэд гарч болох нарийн төвөгтэй асуудлыг тодруулах.

Материал:

- [Сонирхогч талын үзэл бодлын талаарх тараах материал](#)
- [Чиглүүлсэн асуулттай дасгалын хуудас](#)
- Цаг

Процесс:

- 1) Чиглүүлсэн асуулттай дасгалын хуудасны нэгдүгээр алхмыг гүйцэтгэж дууссаны дараа хэлэлцүүлгийн формат болон процессыг сурагчдад танилцуулна уу.
- 2) Хэлэлцүүлгийг багш зохицуулж удирдах бөгөөд зохион байгуулалттай форматын дагуу явуулна:
 - a) Сонирхогч талууд болон тэдний төсөлд гүйцэтгэх үүргийг танилцуулах (хүн бүр 1 минут, бусад оролцогчоос санал шүүмж хэлэхгүй)
 - b) Зохицуулалттай сэдвүүд (нээлттэй хэлэлцүүлгийн форматаар хүн бүр 5 минут)
 - i) Сэдэв 1 – Малчдын амьжиргаа ба амьдралын хэв маяг
 - ii) Сэдэв 2 – Экологийн эрүүл мэнд (үүний дотор ямааны эрүүл мэнд)
 - iii) Сэдэв 3 – Эдийн засгийн хөгжин цэцэглэлт
 - c) Сонирхогч талуудаас өөрсдийн хамгийн онцлог санаагаа тодорхойлсон дүгнэлтүүд гаргах (хүн бүр 1 минут, бусад оролцогчоос санал шүүмж хэлэхгүй).
- 3) Хэлэлцүүлгийн формат, процессыг танилцуулсан бол сонирхогч тал тус бүрд Чиглүүлсэн асуулттай дасгалын хуудсан дээр үндэслэн өөрсдийн үүрэг, байр сууриа танилцуулах 1 минут өгнө.

- 4) Судалгаа хийж, удахгүй болох орон нутгийн хэлэлцүүлэгт бэлтгэх цаг өгнө. Энэхүү хэлэлцүүлэг нь ноолуурын худалдааны салбарт ашиг сонирхол бүхий талуудын хооронд зөвшилцөл бий болгоход туслах зорилготой. Одоогоор аль ч тал тус салбарт бүрэн дүүрэн сэтгэл хангалуун бус байгаа бөгөөд сонирхогч тал бүрийн баримталж буй өвөрмөц байр суурь нь бусадтайгаа зөрчилдөж байгаа юм.
- а) Сурагчдын зорилго нь сонирхогч талын хувьд хамгийн ашигтай байр суурийг хамгаалахад оршино. Тэд зөвшилцөж буулт хийх ёстой ч гол нь хэлэлцүүлгээс аль болох их зүйлийг олж авах шаардлагатай.
- 5) Хэлэлцүүлэгт оролцох төлөвлөгөө гаргахдаа Чиглүүлсэн асуулттай дасгалын хуудасны нэгдүгээр алхмыг хэрэглэхийг сурагчдад зааварла. Тэгээд зорилгоо тогтоож эхлэхийг даалгаарай!
- 6) Ноолуурын тогтвортой төслийн мэтгэлцээний 2-р хэсэг рүү шилжихээс өмнө сурагчдад Чиглүүлсэн асуулттай дасгалын хуудсан дээрээ ажиллах цаг олго.

 WCS presents

FIELD SIGHT

"WCS Education" болон манай байгалийн
цогцолборт газрын хөтөлбөрийн талаар
мэдээлэлт олж авахыг хүсвэл
wcs.org/education хаягаар орж үзнэ үү



@WCSEducation



@WCSEducation